

**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН 2014 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Зорилт 1. Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох		
1.	<p>Улсын Их Хуралд хэлэлцэх хууль, УИХ-ын бусад шийдвэр, төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцлөөр хангах.</p> <p>/Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1/</p>	<p>Ашигт малтмалын тухай хууль болон салбарын бусад хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж батлуулахтай холбоотой төрийн байгууллага, төрийн бус байгууллага, уул уурхайн хөдөлгөөн, эрдэмтэд судлаачдын санал хүсэлтийг авах ажлыг зохион байгуулж, ажлын хэсэгт орж ажиллаж хуулийн төсөлд санал хүргүүлсэн.</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцлөөр хангах зорилгоор тэдгээрийн санал хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах ажлыг Ашигт малтмалын газрын веб сайтад байршуулах ажил хийгдэж байна.</p>
2.	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>1.Ашигт малтмалын газрын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг тус газрын дарга баталж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил болон энэ төлөвлөгөөний дагуу хийгдэх ажил түүнийг хариуцаж хийх албан тушаалтны жагсаалтыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга баталж, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.</p>
3.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлөөр хангах.</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг байгууллагын ажилтан албан хаагчдад сурталчилах зорилгоор байгууллагын мэдээллийн цагаар яриа танилцуулгыг хийсэн.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг нийтийн албанд таниулах сургалтыг Ардчилалын ордонд зохион байгуулан нийт 36 албан хаагч хамрагдсан.</p>

	/Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/	Авлигатай тэмцэх газраас нийтэлсэн “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”-ыг байгууллагын нийт албан хаагчидад тарааж өгсөн.
4.	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, харилцан санал солилцох</p> <p>/Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5/</p>	<p>1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдсантай холбогдуулан хуульд заасан маягтуудыг Ашигт малтмалын газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн а-36 тоот тушаалаар баталсан. Эдгээр маягтуудын дагуу тусгай зөвшөөрлийг олгож ажиллах чиглэл болон зөвлөмжийг аймаг, нийслэлийн дарга нарт өгсөн. Мөн орон нутгын тухайн асуудлыг ажилтнуудад сургалт явуулахаар бэлтгэж байна.</p> <p>2.Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 440 дүгээр тушаалаар батлагдсан “Уулын ажлын төлөвлөгөө, тайлан цахим хэлбэрээр хүлээн авах дотоод заавар”-т өөрчлөлт оруулах төслийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт танилцуулах зорилгоор Уул уурхайн үндэсний ассоциатай хамтран 36 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хамруулсан семинар зохион байгуулав.</p> <p>3.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу хийгдэх “Орон нутгийн хөгжлийг дэмжих, хамтран ажиллах гэрээ”-ний төслийг сумын засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, салбарын мэргэжлийн холбоотой хамтран хэлэлцлсэн.</p>
5.	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>/Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/</p>	<p>1. Хэлтсийн хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр хийх 2014 оны ажлын календарчилсан төлөвлөгөөнд нийт 15 ажил үйлчилгээг тусган хуваарийн дагуу дотоод хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2. Хийсэн хяналт шалгалтынхаа үр дүнг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд тухай бүрд нь танилцуулан шаардлагатай арга хэмжээг авж ажилласан.</p> <p>3. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, холбогдох арга хэмжээ авсан байна/. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Уул уурхайн шинжилгээ, туршилтын лабораторийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, ажлын байрны чиг үүргийн зохион байгуулалт, ажлын үр бүтээмж, ажлын ачааллын байдалд хяналт-шинжилгээг дуусгаж танилцуулаад албан даалгавар гаргаж арга хэмжээ авсан. • “Могол интернешнл” ХХК-ийн эзэмшиж буй 18 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд хяналт-шинжилгээ хийж удирдлагад танилцуулсан. • “Хувийн хэргийн бүрдүүлэлтийн байдал болон хүний нөөцийн программ ашиглалтын байдалд хяналт шинжилгээ хийж зөвлөмж гарган удирдлагад танилцуулсан. Холбогдох ажлууд хийгдсэн.

		<ul style="list-style-type: none"> • 2014 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт тавьсан. Аудитаар зөрчил дутагдал илрээгүй. Үр дүнг удирдлагад танилцуулсан. • 2013 оны дотоод болон гадаад томилолтын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийн Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд ДДЗХ-д 2014 оны 2-р сарын 13-ны өдөр танилцуулсан. Цаашид анхаарах ажлуудыг хэлэлцэж томилолтын журам боловсруулж батлуулсан. • АМГ-ын ажилтнуудын ажлын ачааллын байдалд хяналт-шинжилгээ хийн ДДЗХ-д 2014 оны 2-р сарын 13-ны өдөр танилцуулсан. Судлагааны дагуу бүтэц зохион байгуулалтын саналуудыг боловсруулсан. Өөрчлөлт хийгдсэн. • 2013 оны хээрийн шуурхай хяналтаар хайгуулын ажил хийгдээгүй тусгай зөвшөөрлүүдийг цуцлах үйл ажиллагаа тасалдсан талаар судлаж агентлагийн дарга болон хэлтсийн дарга нарт танилцуулсан. <p>АМГ-ын даргын баталсан тушаал, удирдамжийн дагуу Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэг ажилласан. Агентлагын хэмжээнд гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй 5 төслийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээний хийсэн</p>
6.	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хувиарлалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх</p> <p>/Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл/</p>	<p>1.Байгууллагын цахим хуудсанд 2014 оны төсөв, 2013 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны аудитын тайлан, 2013 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайлан, Санхүүгийн эдийн засгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг тухай бүр шинэчлэн тус тус байршуулсан.</p>
7.	<p>Байгууллагын чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p>	<p>1.Кадастрын хэлтэс нь тусгай зөвшөөрөл болон түүний эзэмшигчтэй холбоотой талбайн зураг болон жагсаалтыг байгууллагын дотоод цахим хуудсанд тогтмол байршуулж байна.</p> <p>2.2014 оны 9 дүгээр сарын байдлаар Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 97 тусгай зөвшөөрөл цуцалсан, 240 дуусгавар болгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.</p>

	<p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8/</p>	<p>3. Засгийн газрын 2014 оны 216 дугаар тогтоолын дагуу 106 тусгай зөвшөөрлийн талбайд сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2014 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн а-66 дугаар тушаал гарсан. Үүнээс 14, 10, 9 талбайг тус тус багцлан сонгон шалгаруулалт явуулах саналыг нийтэд сонин болон байгууллагын цахим хаягт байршуулсан.</p> <p>4. Уул уурхайн салбарт ажилладаг гадаад болон дотоодын ажилчдын тоог 2012-2013 оны байдлаар гаргаж цахим хаягт байршуулсан.</p>
<p>8.</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор ханган</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл/</p>	<p>1. Сул 4 орон тоог Төрийн албаны зөвлөлд санал болгож төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгч нөөцөд орсон иргэдээс нөхөв.</p>

9.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4,</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухайн хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5</p>	<p>1.Хөрөнгө оруулалт 2014 оны байгууллагын төсөвт мөнгө батлагдаагүй тул тендер зохион байгуулагдаагүй болно. Урсгал зардлаар худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авалтыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: Бичгийн цаас, принтерийн хор, харуул хамгаалалтын хөлс, програм хангамж, гадна байрлах лэд дэлгэц, нэг цэгийн үйлчилгээний засварын ажил, сервер зэргийг худалдан авахдаа харьцуулалтын аргаар зохион байгуулж шаардлагад нийцсэн, хамгийн бага үнийн санал ирүүлсэн компанийг шалгаруулан гэрээ байгуулан худалдан авалтыг хийж гүйцэтгэж байна. Урсгал зардлаар ХАА-ны төлөвлөгөөг гарган улирал бүр худалдан авах ажиллагааны тайланг гарган УУЯ-нд хүргүүлж байна</p>
10.	<p>Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6,</p>	<p>2012 оны 10 дугаар сард тус агентлагын нийт 170 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг 2014 онд шиэчилэн баталсан. 2014 оны 3 дугаар улиралд 6 ажлын байрны тодорхойлолтыг шинээр баталсан.</p>
11.	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах</p>	<p>байхгүй</p>

	<p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13</p>	
12.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх.</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.18,</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2</p>	<p>1. Ашигт малтмалын газрын даргын 2013 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 384 дүгээр тоот тушаалаар Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Болорцэцэгийг байгууллагын эрх бүхий албан тушаалтнаар томилсон. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан түүний ажлын байрны тодорхойлолтод хийх ажлын жагсаалтад өөрчлөлт оруулав.</p>
13.	<p>Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх, шинэчлэх</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл,</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.8, 6.1.6,</p>	<p>Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 210 дугаар тушаалын хавсралтаар баталсан “байгууллагын ёс зүйн дүрэм”-ийг шинэчилэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p>

14.	<p>Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл,</p>	<p>Байгууллагын хэмжээнд нийт 32 ажилтан давхар албан тушаалд ажиллаж байна. /судалгааг хавсралтаар/</p>
15.	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5,</p>	<p>1.Удирдлагаас гарч буй шийдвэр, мэдэгдэлүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр болон байгууллагын цахим хуудас мөн хэлтсийн мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна.</p> <p>2.Кадастрын хэлтэс нь Үйлчлүүлэгчээс хүлээн авсан үйлчилгээний хөлс болон төлбөрийн статистк мэдээллүүд болон тайланг яам төрийн байгууллагуудад мэдээллэж, энэ талаар байгууллагын цахим хуудсанд байршуулж байна.</p> <p>3.Ашигт малтмалын хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, тэдгээрийн шилжилт хөдөлгөөн, шинээр олгосон тусгай зөвшөөрөл, хүлээн авсан өргөдлийн талаархи статистик мэдээ, харьцуулсан судалгааг сар бүр гарган хэлтэс, тасгийн дарга нарт танилцуулж, байгууллагын вэб сайтад тавьж, өдөр тутмын сонин болон “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ” сонинд хэвлүүлж нийтэд мэдээлж байна.</p>
16.	<p>Иргэдийн өргөдөл /санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаархи мэдээллийг хүлээн авч шалгах</p>	<p>1.2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 6260 хүсэлт, 314 өргөдөл, гомдол өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэж хуулийн хугацаанд хариуг хүргүүлсэн байна.</p> <p>2.Байгууллагын 2 давхарт кадастрын нэг цэгийн үйлчилгээг байгуулж ажилласнаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын өргөдлийг богино хугацаанд шийдвэрлэн ажиллах боломж бүрдсэн.</p>

	<p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11</p> <p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2,</p>	<p>3.Геологийн салбарын 60 гаруй компаний 2411 хүнд 5130 тайлан, 7872 ном, 14 уут анхдагчаар, мэргэжлийн 14 номоор, А4+А3 хэмжээгээр 45000 хуудас баримт хувилах үйлчилгээ үзүүлж, 394 ш өнгөт зургийг скайнердан өгч, улсын төсөвт 90,5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан.</p>
17.	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1</p>	<p>1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал, үйлчилгээний судалгааг гаргаж Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн.</p> <p>2.АМГ-ын дарга нь үндсэн үйл ажиллагааны чиглэлээр болон боловсон хүчний чиглэлээр тушаал гаргадаг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарах тушаалуудаас нөөц бүртгэх тушаал болон техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах тухай тушаал нь тухайн компанийн хувийн хөрөнгөөөр хийгдсэн ажлын тайлан үр дүн байдаг учраас, нийтэд мэдээлэх боломжгүй байдаг.</p> <p>Харин нийтэд чиглэсэн дүрэм, журам, зааврыг гарсан даруйд нь ашигт малтмалын газрын веб сайт болох www.mram.gov.mn хаягт байршуулж байгаа.</p>
18.	<p>Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т мэдээлэх</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3,</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2,</p>	<p>Байхгүй</p>
19.	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу</p>	<p>Авлигатай тэмцэх газрын ирүүлсэн зөвлөмжийн дагуу ажиллаж, тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.</p>

	<p>гаргасан шийдвэрийг биелүүлэх ажлын хүрээнд</p> <p>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4,</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2,</p>	
20.	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт</p>	<p>2014 оны 10 сард Ашигт малтмалын газрын даргын санаачилгаар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт сэдэв”-ийн талаарх сургалтыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газрын холбогдох хэлтсийн мэргэжилтнийг урьж, лекц, харилцан асуулт хэлбэрээр зохион байгуулав.</p> <p>Байгууллагын сургалт, семинарийн хөтөлбөр, зардлах батлах тухай тус газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн б-167 тушаалаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт сэдэвтэй сургалтад 4,5 сая төгрөгийг төсөвлөж зарцуулсан болно.</p>
21.	<p>Албан хаагчдын шудрага байдлыг нэмэгдүүлэх</p>	<p>Байгууллагын ажилтны ажлын бүртгэлийг сайжруулах, хоцрогдлыг бууруулах зорилгоор ажил албан тушаал харгалзахгүйгээр цагын бүртгэлд хяналт тавьж ажиласны үр дүнд нийт ажиллагдсадын ажлын цаг ашиглалт дээшилсэн.</p>

--oOo---

Танилцсан:

Төрийн Захиргааны, удирдлагын хэлтсийн дарга

Хянасан

Эрх зүй, хуулийн тасгийн дарга

Н.Алтанцог

С.Дашдаржаа

Боловсруулсан:

Эрх зүй, хуулийн тасгийн мэргэжилтэн, ЭБАТ

Б.Болорцэцэг